



**ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/450

Зуунмод

Төвийн бүсийн арга хэмжээний
зардал гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6, Засгийн газрын 2004 оны 28 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төв бүсийн зөвлөлийн 2022 оны ээлжит хурлыг хуралдуулж, бүсийн “Улсын тэргүүний сум шалгаруулах” зохион байгуулалтыг бүрэн хангаж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Д.Саран-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.


2. Бүсийн зөвлөлийн хуралдааны арга хэмжээнд зарцуулагдах 2,663,100 (хоёр сая зургаан зуун жаран гурван мянга нэг зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР



Аймгийн Засаг даргын 2022 оны
03 дүгээр сарын 15-ны өдрийн
А/150 дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хүний тоо	Нэг бүрийн үнэ	Нийт зардал
1	Хуралдааны цай кофе	30	6600	197.000
2	Хоолны зардал 3 удаа	30	18000	1620.000
13	Заалны түрээс	4 цаг	150000	600.000
Дүн				2.421.000
НӨАТ				242.100
Бүгд дүн				2663100

ТӨСӨВ ГАРГАСАН:
ХБТХОХ-ИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

А.ТУУЯАЖАРГАЛ

ХЯНАСАН:
СТСХ-ИЙН ТӨСВИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

Ч.ЦЭЦЭГСҮРЭН

